

Хүсэлт гаргах, зөвшөөрөл авах үйл явц

(Санамж) Өргөдлийг нягталж үзэн, хариу өгөхөд дор хаяж 2 долоо хоногийн хугацаа зарцуулагдах ба хүсэлт гаргасан цаг хугацаа, агуулгаас хамааран нааш, цааш өөрчлөгдөх магадлалтайг анхаарна уу.

Арга хэмжээний агуулгын хувьд загварын дагуу шаардлагатай хэсгүүдийг бөглөн, шаардлагатай бичиг баримтын хамт и-мэйл, факс, шуудангаар илгээнэ.

1. Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яам хяналт, шалгаруулалт хийх
2. Хяналт, шалгаруулалтын хариуг мэдэгдэх

Хяналт, шалгаруулалтын үр дүнг тус арга хэмжээг хариуцсан хүнд мэдэгдэнэ. Зөвшөөрөл олгогдож, бүртгэгдсэн арга хэмжээнд “Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой”-н логог цахим хэлбэрээр илгээх тул зааврын дагуу ашиглана уу.

3. Арга хэмжээний хуанлид байршуулах

Зөвшөөрөл олгогдон, ойн арга хэмжээнд бүртгэгдсэн тохиолдолд таны илгээсэн мэдээлэл дээр үндэслэн Япон улс, Монгол улс хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойн арга хэмжээний хуанлид байршуулах болно. Мөн ойн арга хэмжээтэй хамааралтай цахим хуудсын хувьд шууд холбоосыг байршуулах тохиолдол ч бий.

(Санамж) Ойн арга хэмжээнд шууд холбогдолгүй цахим хуудас руу үсрэх холбоосыг байршуулахгүй. Мөн 45 жилийн ойн хуудаст мэдээлэл байршуулсны дараа тусгайлан мэдэгдэхгүй тул анхаарна уу.